



ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ  
ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН АЛБА

**ХОЁР, ГУРАВ ДАХЬ ШАТЛАЛЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН  
БАЙГУУЛЛАГАД АШИГЛАГДАЖ БАЙГАА ЭМНЭЛГИЙН  
ХИЙН ХАНГАМЖИЙН СИСТЕМИЙН ӨНӨӨГИЙН  
БАЙДЛЫН СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

УЛААНБААТАР ХОТ

2017 он

**АГУУЛГА**

Нэг. Судалгааны үндэслэл, судлагдсан байдал	3
Хоёр. Судалгааны арга зүй	5
Гурав. Судалгааны үр дүн	10
3.1 Хийн хангамжийн систем хариуцан ажилладаг хүний нөөцийн мэдээлэл	10
3.2 Хийн хангамжийн системийн ашиглалтын өнөөгийн байдал	13
3.3 Хийн хангамжийн системийн хэрэгцээ шаардлага	18
3.4 Хийн хангамжийн системийн сургалт, аюулгүй ажиллагаа	19
3.5 Хийн хангамжтай холбоотой гарсан осол гэмтэл	20
Дөрөв. Дүгнэлт	22
Хавсралт	25

## НЭГ. СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд шаардлагатай хүчин зүйлүүдийг нэг бол эмнэлгийн хийн хангамжийн систем юм. Сүүлийн жилүүдэд эрүүл мэндийн байгууллагуудын барилга шинэчлэгдэн засварын ажил ихээхэн хийгдэж байгаа ч дэд бүтцийн асуудал буй эмнэлгийн хийн хангамжийн системийг орхигдуулж байна. Эрүүл мэндийн салбарт үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчийн байгууллагад ашиглагдаж байгаа эмнэлгийн хийн хангамжийн систем өөр өөр түвшинд байна.

Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/143 дугаар тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн байгууллагуудын эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалт, үйл ажиллагаатай танилцах” ажлын хэсэг 5 баг болж хуваагдан 2016 оны 12 сард 21 аймагт 5 чиглэлд зэрэг ажилласан. Ажлын хэсэг 8 зорилтын хүрээнд ажилласан ба зорилт 1-ийн хүрээнд тухайн аймгийн эрүүл мэндийн газар, нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн удирдлага, инженер техникийн ажилтантай уулзаж ярилцан, эмнэлгийн барилга байгууламж, цахилгаан систем, эмнэлгийн хийн хангамжийн систем, агааржуулалт, газардуулгын системтэй танилцаж тулгамдаж буй асуудлыг судалсан.

Ингэхэд 21 аймгийн 33 хувь хэсэгчилсэн хүчилтөрөгчийн системтэй, үлдсэн 67 хувь эмнэлгийн хийн хангамжийн системгүй байсан тул уг ажлын хэсгийн тайланд хангалтгүй гэж дүгнэгдсэн. Иймд нийслэлийн болон аймгийн төрийн өмчийн хоёр, гурав дахь шатлалын эрүүл мэндийн байгууллагад ашиглагдаж байгаа эмнэлгийн хийн хангамжийн системийн өнөөгийн байдлыг судлах шаардлага тулгарсан нь энэхүү судалгааны үндэслэл болж байна.

**Судалгааны зорилго:** Хоёр, гурав дахь шатлалын эрүүл мэндийн байгууллагад ашиглагдаж байгаа эмнэлгийн хийн хангамжийн системийн өнөөгийн байдлыг тодорхойлох.

### **Зорилт:**

- Эрүүл мэндийн байгууллагын хийн хангамжийн систем хариуцан ажилладаг хүний нөөцийн судалгаа хийх;
- Хангамжийн системийн өнөөгийн байдлыг үнэлэх;
- Эрүүл мэндийн байгууллагын хийн хангамжийн системийн бүдүүвч зураглалыг баримтжуулан авах;

- Эрүүл мэндийн байгууллагад цаашид шаардлагатай хийн хангамжийн тооцоо хийх.
- Эрүүл мэндийн байгууллагын эмч, сувилагч болон ажилчдад зориулсан аюулгүй ажиллагаа болон сургалт явуулах үйл ажиллагааг үнэлэх;
- Хийн хангамжтай холбоотой гарсан осол гэмтэл бүртгэх;

**Судалгаанаас гарах үр дүн:** Хоёр, гурав дахь шатлалын эрүүл мэндийн байгууллагад ашиглагдаж байгаа эмнэлгийн хийн хангамжийн системийн өнөөгийн байдлыг үнэлж, цаашид авах арга хэмжээ тодорхойлж, бодлого боловсруулагч болон шийдвэр гаргагчдыг мэдээллээр хангана.

## ХОЁР. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

### 2.1 Эмнэлгийн хийн хангамжийн системийн өнөөгийн байдлын судалгааны таамаглаж буй үр дүн

Энэхүү судалгааг хийснээр хоёр, гурав дахь шатлалын эрүүл мэндийн байгууллагад ашиглагдаж байгаа эмнэлгийн хийн хангамжийн системийг нэгдсэн бодлого, стандартын дагуу байгуулах, шаардлагатай эрүүл мэндийн байгууллагад хүчилтөрөгчийн үйлдвэрийн бий болгож эмнэлгийн тусламж үйлчилгээг чанартай хүргэх боломж бүрдэнэ.

### 2.2 Эмнэлгийн хийн хангамжийн системийн өнөөгийн байдлын судалгааны арга зүй ба хамрах хүрээ

**Судалгааны арга:** Судалгааг тусгайлан боловсруулсан асуумжийн дагуу мэдээлэл цуглуулсан.

**Судалгааны хамрах хүрээ:** Судалгаанд төрийн өмчийн хоёр, гурав дахь шатлалын нийт 44 эрүүл мэндийн байгууллагад буюу Эрүүл мэндийн яамны харьяа 3 төв эмнэлэг, 8 тусгай мэргэжлийн төв, Нийслэлийн эрүүл мэндийн газрын харьяа дүүргийн 9 эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлэг, 3 амаржих газар, 4 бүсийн оношилгоо, эмчилгээ төв, 16 аймгийн нэгдсэн эмнэлэг тус тус хамрагдсан.

**Хугацаа:** 2017 оны 07 дугаар сарын 24-оос 8 дугаар сарын 18-ны хооронд гүйцэтгэнэ.

### 2.3 Судалгааны ажиллах хүчин:

- Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Эмнэлгийн тоног төхөөрөмжийн алба;
- Эрүүл мэндийн байгууллагын хийн хангамжийн систем болон хүчилтөрөгчийн инженер, техникийн ажилтнууд;

### 2.4 Мэдээлэл цуглуулах хэрэгсэл:

- Судалгааны удирдамж болон асуумжийг төрийн өмчийн хоёр, гурав дахь шатлалын эрүүл мэндийн байгууллагад албан бичгээр хүргүүлэх;
- Судалгааны ажил эхлэхийн өмнө эмнэлгийн хийн хангамжийн систем болон хүчилтөрөгч хариуцан ажилладаг ажилтанд судалгааны асуумж хэрхэн бөглөх талаар зааварчилгаа өгөх;
- Эрүүл мэндийн байгууллагын инженер техникийн алба болон хийн хангамжийн систем болон хүчилтөрөгчийн асуудал хариуцсан ажилтан нь тусгайлан боловсруулсан асуумжийг бөглөн, цахим шуудангаар илгээх;

**2.5 Судалгааны мэдээлэл боловсруулах:** Судалгааны асуумжийн дагуу дүн шинжилгээ хийх ба боловсруулалтын явцад тодорхой бус мэдээллийг цахимаар болон утсаар, биечлэн очиж тодруулга хийж, тайлан бичнэ.

**2.6 Мэдээллийг түгээх:** Бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчдад судалгааны тайланг албан бичгээр хүргүүлнэ.

**2.7 Судалгааны асуумж:** Нийт 89 асуумжийг 5 бүлэг хуваан хуваасан. Үүнд:

2.7.1 Хийн хангамжийн систем хариуцан ажилладаг хүний нөөцийн мэдээлэл

1	Хүчилтөрөгчийн инженертэй эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
	Тийм бол инженерийн тоо	.....	
2	Хүчилтөрөгчийн техникчтэй эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
	Тийм бол техникчийн тоо	.....	
3	Хүчилтөрөгчийн операторчтой эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
	Тийм бол операторчийн тоо	.....	
4	Ажлын цаг	<input type="checkbox"/> 4 ээлжээр 24 цаг	<input type="checkbox"/> Ажлын 8 цаг
	<input type="checkbox"/> Бусад	.....	
5	Аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгдөг эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
6	Аюулгүй ажиллагааны зааварчилгаа хэн өгдөг вэ?	<input type="checkbox"/> Албаны дарга	<input type="checkbox"/> Инженер
		<input type="checkbox"/> ХАБЭАА	<input type="checkbox"/> Техникч
7	Аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх давтамж	<input type="checkbox"/> Шинэ ажилтанд	<input type="checkbox"/> Улирал тутам
		<input type="checkbox"/> Сар тутам	<input type="checkbox"/> 7 хоног тутам
		<input type="checkbox"/> Өглөө бүр	<input type="checkbox"/> Ажлын эхлэхийн өмнө
8	Хамгаалалтын хувцсаар байгууллага хангадаг эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
9	Хамгаалалтын хувцас /ажлын хувцас, гутал, бээлий/-ыг шинэчилдэг хугацаа	<input type="checkbox"/> Жил тутам	<input type="checkbox"/> Хагас жил тутам
10	Шаардлагатай багаж, хэрэгсэл /түлхүүр, тэргэнцэр, тэргэнцрийн дугуй гэх мэт/-ээр хангадаг эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
11	Шаардлагатай сэлбэг хэрэгсэл /редуктор, толгой/-ээр хангадаг эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй

\* 8 дугаар асуултыг зургаар баталгаажуулах

№	Овог нэр	Албан тушаал	Мэргэжлийн үнэмлэхийн дугаар	Үнэмлэх ний хугацаа	Сургалт зохион байгуулсан байгууллага	Сургалтад хамрагдсан хугацаа	Сургалтаас авсан мэдээлэл хангалттай эсэх	
1							<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
2							<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
3							<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
4							<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
5							<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
6							<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
7							<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй

2.7.2 Хийн хангамжийн системийн ашиглалтын өнөөгийн байдал

1	Хүчилтөрөгчийн үйлдвэртэй эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
2	Хүчилтөрөгчийн үйлдвэрийн байршил	.....	
3	Хариуцан ажилладаг ажилтны тоо	.....	
4	Хариуцан ажилладаг албан тушаалтан	.....	
5	Нэг хүчилтөрөгчийн баллон цэнэглэх хугацаа	.....	
6	Нэг зэрэг цэнэглэх боломжтой хүчилтөрөгчийн баллоны тоо	.....	
7	Хоногт цэнэглэх боломжтой хүчилтөрөгчийн баллоны тоо		
8	Эмнэлгийн хүчилтөрөгчийн нөөцийн хангадаг эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
9	Хүчилтөрөгчийн баллоныг нөөцөлдөг эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
10	Өдөрт нөөцлөх хүчилтөрөгчийн баллоны тоо		
11	Хүчилтөрөгчийг хэрхэн түгээдэг	.....	
12	Нөөц хүчилтөрөгчийг борлуулдаг эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
13	Ямар ЭМБ-д борлуулдаг	.....	
14	Нэг баллон хүчилтөрөгчийн үнэ	.....	

№	Тасгийн нэр	Хийн нэгдсэн системтэй эсэх			Хэсэгчилсэн хүчилтөрөгчийн систем		Зөөврийн хүчилтөрөгч ашигладаг	
		Тийм	Үгүй	Хэсэгчилсэн систем	Тийм	Үгүй	Тийм	Үгүй
1								
2								
3								
4								
5								
6								
7								
8								
9								
10								

\*Хийн нэгдсэн систем болон хэсэгчилсэн хүчилтөрөгчийн системийг бүдүүвч зургийг судалгаанд хавсаргана.

1	Хийн нэгдсэн системтэй эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй	
2	Хийн нэгдсэн систем нь	<input type="checkbox"/> Хүчилтөрөгч	<input type="checkbox"/> Агаар	<input type="checkbox"/> Вакуум

\*Хүчилтөрөгчийн үйлдвэрийн хүчин чадлын болон хийн нэгдсэн системд ашиглаж байгаа агаарын компрессорын техник үзүүлэлтийг ирүүлэх.

1	Баллонтой хүчилтөрөгч худалдан авдаг эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
2	Хүчилтөрөгч татан авалтын хугацаа	<input type="checkbox"/> Өдөр бүр	<input type="checkbox"/> 2-4 хоногт
		<input type="checkbox"/> 5-7 хоногт	<input type="checkbox"/> 7-10
		<input type="checkbox"/> түүнээс дээш	
3	Тээвэрлэлтийг аль байгууллага хариуцдаг		
4	Тээврийн хэрэгслийн аюулгүй байдлыг хангагдсан эсэх	<input type="checkbox"/> Дэр мод	<input type="checkbox"/> Осолын тэмдэг
		<input type="checkbox"/> Улаан туг	<input type="checkbox"/> Аюултай ачаа
5	Баллонтой хүчилтөрөгч ирэх үед хэн буулгадаг		
6	Хүчилтөрөгчийн баллоны хадгалах байртай эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
7	Хадгалах байрны байршил		
8	Хадгалах байр нь дараах шаардлагыг хангасан	<input type="checkbox"/> Гадна хүн орохыг хориглоно тэмдэглээ	
		<input type="checkbox"/> Тэсэрч дэлбэрэх аюултай гэсэн тэмдэглэгээ	
		<input type="checkbox"/> Баллоны бэхэлгээ	
9	Эмнэлгийн дотор зөөвөрлөлтийг хэрхэн гүйцэтгэдэг	<input type="checkbox"/> Зориулалтын тэргэнцэр	
		<input type="checkbox"/> Зориулалтын бусаар зөөвөрлөх	
		<input type="checkbox"/> Давхар хооронд цахилгаан шатаар зөөвөрлөдөг	
10	Хийн нэгдсэн болон хэсэгчилсэн хүчилтөрөгчийн системд нэг удаад хэдэн баллон зэрэг залгадаг		
11	Баллон сэлгэлт ямар аргаар хийгддэг	<input type="checkbox"/> Автомат	<input type="checkbox"/> Гар аргаар
12	Нэг циклээр хэдэн цаг үйлчлэх		

\* 4, 5, 6 дугаар асуултыг зургаар баталгаажуулах

### 2.7.3 Хийн хангамжийн системийн хэрэгцээ шаардлага

№	Цаашид хийн системтэй болох шаардлагатай тасаг нэгжийн нэр	Орны тоо	Шаардлагатай			Шаардлагатай төсөв
			Хийн нэгдсэн систем	Хэсэгчилсэн хүчилтөрөгчийн систем	Баллоны тоо	
1						
2						
3						
4						
5						
6						
7						
8						
9						
10						



№	Асуумж	
1	Байгууллагын үндсэн хөрөнгийн бүртгэлтэй хүчилтөрөгчийн баллоны тоо	
2	Шаардлагатай хүчилтөрөгчийн баллоны тоо	
3	Байгууллагын үндсэн хөрөнгийн бүртгэлтэй нүүрстөрөгчийн баллоны тоо	
4	Шаардлагатай нүүрстөрөгчийн баллоны тоо	

2.7.4 Хийн хангамжийн системийн сургалт, аюулгүй ажиллагаа

1	Эмч, сувилагч нарт зориулсан аюулгүй ажиллагааны сургалт явуулдаг эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
2	Аюулгүй ажиллагааны сургалтын давтамж	<input type="checkbox"/> Жил бүр	<input type="checkbox"/> Хагас жил бүр
3	Хамгийн сүүлд хэзээ сургалт зохион байгуулсан вэ?	.....	
4	Сургалтад хамрагдсан эмч сувилагч нарын тоо	.....	
5	Хийн системтэй ажиллах шинээр ажилд орж буй эмч сувилагч нарт аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгдөг эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
6	Хүчилтөрөгчийн систем болон баллонтой ажиллах аюулгүй ажиллагааны зааварчилгаатай эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
7	Уг зааварчилгыг хэрэглэгчийн ойр газар байршуулдаг эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
8	Аюулгүйн тэмдэг тэмдэглэгээ ашигладаг эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй

\* 6 дугаар асуултыг зургаар баталгаажуулах

2.7.5 Хийн хангамжтай холбоотой гарсан осол гэмтэл

1. Хийн хангамжийн систем, хүчилтөрөгчтэй харьцан ажиллах аюулгүй ажиллагааг зөрчсөнөөс болон бусад хүчин зүйлсээс шалтгаалсан осол гэмтэл гарсан эсэх:	
<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
2. Тийм бол товч мэдээллийг оруулах:	
3. Уг осол гэмтэл үүсэх болсон шалтгаан:	
4. Хэрхэн шийдвэрлэсэн:	


## ГУРАВ. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Судалгаанд төрийн өмчийн хоёр, гурав дахь шатлалын нийт 44 эрүүл мэндийн байгууллагад буюу Эрүүл мэндийн яамны харьяа 3 төв эмнэлэг, 8 тусгай мэргэжлийн төв, Нийслэлийн эрүүл мэндийн газрын харьяа дүүргийн 9 эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлэг, 3 амаржих газар, 4 бүсийн оношилгоо, эмчилгээ төв, 16 аймгийн нэгдсэн эмнэлэг тус тус хамрагдсан.

### 3.1 ХИЙН ХАНГАМЖИЙН СИСТЕМ ХАРИУЦАН АЖИЛЛАДАГ ХҮНИЙ НӨӨЦИЙН МЭДЭЭЛЭЛ

Төрийн өмчийн хоёр, гурав дахь шатлалын эрүүл мэндийн байгууллагуудад эмнэлгийн хийн хангамжийн систем хариуцан ажилладаг хүний нөөцийн мэдээлэл чухал юм. 2017 оны 9 дүгээр сарын байдлаар судалгаанд хамрагдсан ЭМЯ-ны харьяа төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдэд 36, НЭМГ-ын харьяа амаржих газар, нэгдсэн эмнэлэгт 16, орон нутгийн буюу бүсийн оношилгоо, эмчилгээний төв, нэгдсэн эмнэлэгт 25, нийт 77 ажилтан эмнэлгийн хийн хангамжийн системийг хариуцан ажиллаж байна. Албан тушаалыг хариуцан үзэхэд албан ёсны орон тооны дагуу 4 хүчилтөрөгчийн инженер, 21 хүчилтөрөгчийн техникч, 28 хүчилтөрөгчийн оператор бөгөөд 29 ажилтан хавсран гүйцэтгэж байна. Албан тушаалын нэршил өөр өөр боловч гүйцэтгэж буй ажлууд ижил төстэй байна.

Эмнэлгийн хийн хангамжийн системийг хариуцан ажилладаг ажилтан хийн хангамж, хүчилтөрөгчийн мэргэшүүлэх сургалттай хамрагдсан байдлыг дараах дүрслэл.1-д харуулав.



Дүрслэл 1. Эрүүл мэндийн байгууллагуудын ажилтнуудын мэргэшүүлэх сургалтад хамрагдсан байдал

Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын хувьд ихэвчлэн эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженерүүд хүчилтөрөгчийн ажлыг хавсран гүйцэтгэдэг бөгөөд мэргэжил олгох сургалтад огт хамрагдаж байгаагүй ба хавсран гүйцэтгэсэн цалингийн нэмэгдэл авдаггүй байна.

*Шигтгээ.1: Би энэ байгууллагад эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженерээр ажилладаг ба насаар л хүчилтөрөгчийн баллон үүрч байгаа боловч ямар нэг хавсран гүйцэтгэсэн цалингийн нэмэгдэл авдаггүй, сургалтад хамрагдаж байгаагүй. Хөдөө орон нутгийн хүчилтөрөгчийн хариуцан ажилтнуудаа нэгдсэн журмаар сургалтад хамруулж, нийгмийн баталгаанд анхаарах хэрэгтэй.*

*Орон нутгийн ЭМБ-ын төлөөлөл*

*Шигтгээ.2: Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженерээр ажилладаг боловч хавсран хүчилтөрөгч хариуцан ажилладаг. Заримдаа ажил ихтэй, ядарч сульдсан үедээ ганцаараа 90 кг жинтэй хүчилтөрөгчийн баллон зөөвөрлөх хүндрэлтэй байдаг.*

*Орон нутгийн ЭМБ-ын төлөөлөл*

Ажлын цагийн хуваарийн хувьд 4 ээлжээр 24 цаг тасралтгүй 7 байгууллага, ажлын 8 цагаар ажилладаг 16 байгууллага байна. Хүчилтөрөгч хариуцсан мэргэжилтэнд аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгдөг 34 байгууллага байна.

### Зааварчилгаа өгдөг албан тушаалтан



*Дүрслэл 2. Хүчилтөрөгч хариуцсан ажилтанд аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгдөг албан тушаалтан*

### Зааварчилгаа өгөх давтамж



Дүрслэл 3. Хүчилтөрөгч хариуцсан ажилтанд аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгдөг давтамж

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 18.2.5 дугаар зүйлд “ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг зориулалтын дагуу хэрэглэх” гэж заасан боловч хүчилтөрөгч хариуцан ажилладаг ажилтанг хамгаалалтын хувцасаар хангадаг 17 эрүүл мэндийн байгууллага байна. Үүнээс 2 байгууллага жилд 2 удаа, 14 байгууллага нь жилд тутамд, жилээс дээш хугацаанд 1 байгууллага хамгаалалтын хувцас хэрэглэлийг шинэчлэл хийдэг байна. Мөн шаардлагатай үед багаж хэрэгсэл (түлхүүр, тэргэнцэр, тэргэнцрийн дугуй)-ээр 24, сэлбэг хэрэгсэл (редуктор, толгой)-ээр 38 эрүүл мэндийн байгууллага тогтмол ханган ажиллаж байна.

**Бүлгийн дүгнэлт:** Эмнэлгийн хийн хангамж хариуцан ажилладаг ажилтны өнөөгийн байдлын харахад эрүүл мэндийн байгууллагуудад хангалттай тооны ажилтан байхгүй байна. Мөн албан тушаалын нэршил өөр өөр боловч хийгдэж байгаа ажил нь төстэй байгаа тул цаашид ажлын байрны тодорхойлолтыг судалж, албан тушаалын нэршлийг тодорхой болгох шаардлагатай байна.

Хөдөө орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудын ажилтанг сургалтад хамруулах, хавсран ажилладаг ажилтны ажлын ачааллыг тооцох, хавсран гүйцэтгэсний цалинг олгож үүрэгжүүлэх шаардлагатай. Ингэж тус ажилтанг үүрэгжүүлснээр ажлын байр дахь идэвх нэмэгдэн аюулгүй ажиллагааны заавар, дүрмийг чандлан сахиж, бусад эрүүл мэндийн ажилтанд тогтмол хугацаанд зааварчилгаа өгч ажиллах боломж бүрдэнэ.

Аюулгүй ажиллагааны зааварчилгааг хариуцан ажилтанд тогтмол ажил эхлэхийн өмнө болон шинэ ажилтан нарт өгч байх, хамгаалалтын хувцас хэрэглэлээр хангаж байх шаардлагуудыг тусгасан нэгдсэн журам, дүрэмтэй болох хэрэгтэй байна.

### 3.2 ХИЙН ХАНГАМЖИЙН СИСТЕМИЙН АШИГЛАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэхэд шаардлагатай зүйлсийн нэг эмнэлгийн хийн хангамжийн систем бөгөөд түүний ашиглалтын өнөөгийн байдлыг судлах нь энэхүү судалгааны гол зорилго юм.

#### 3.2.1 Хүчилтөрөгчийн үйлдвэр

Эрүүл мэндийн салбарын хэмжээнд Улсын нэгдүгээр төв эмнэлэг, Гэмтэл согог судлалын үндэсний төв нь эмнэлгийн хашаанд байрлах хүчилтөрөгчийн үйлдвэртэй бөгөөд хариуцан ажилладаг 1-5 ажилтантай.

*Хүснэгт 1. Хүчилтөрөгчийн үйлдвэрийн үзүүлэлт*

№	Асуумж	Улсын нэгдүгээр төв эмнэлэг	Гэмтэл согог судлалын үндэсний төв
1	Нэг хүчилтөрөгчийн цэнэглэх хугацаа	25-40 минут	1 -2 цагт
2	Нэг зэрэг цэнэглэх боломжтой хүчилтөрөгчийн баллоны тоо	1	6
3	Хоногт цэнэглэх боломжтой хүчилтөрөгчийн баллоны тоо	5-10	6
4	Эмнэлгийн хүчилтөрөгчийн нөөцийн хангадаг эсэх	Тийм	Тийм
5	Өдөрт нөөцлөх хүчилтөрөгчийн баллоны тоо	5-10	10
6	Хүчилтөрөгчийг хэрхэн түгээдэг	Ханын системээр болон зөөврөөр	Ханын системээр болон зөөврөөр
7	Нөөц хүчилтөрөгчийг борлуулдаг эсэх	Үгүй	Үгүй

Гэмтэлтэй согог судлалын үндэсний төвийн хүчилтөрөгчийн үйлдвэрийн үндсэн хүчин чадал нь цагт 16 м<sup>3</sup> хүчилтөрөгч үйлдвэрлэдэг ба нэг баллон цэнэглэх насосны хүчин чадал нь цагт 3.4 м<sup>3</sup> буюу хүчилтөрөгчөөр дүүргэх хугацаа нь 1-2 цаг байдаг.




Зураг 1. ГССҮТ-ийн хүчилтөрөгчийн үйлдвэрийн зураг

Үйлдвэрийн үндсэн хүчин чадал дагуу хүчилтөрөгч үйлдвэрлэж түүнээс ханын системээр дамжуулан тасаг нэгжүүдээ хангалттай хүчилтөрөгчөөр хангадаг. Иймд хүчилтөрөгчийг баллон нөөцлөн худалдах боломжтой. Ажлын 8 цагаар ажиллавал хоногт 4, 24 цагаар ажиллавал 12 ширхэг баллон үйлдвэрлэх бүрэн боломжтой ба хүний нөөц ч хангалттай ажиллах чадвартай.

Уг хүчилтөрөгчийн үйлдвэр Франц улсын эрүүл мэндийн төслийн санхүүжилтээр баригдан 2014 оны 5 дугаар сард ашиглалтад орсон ба одоо урсгал засваруудыг төслөөс санхүүжүүлдэг. Төслийн хугацаа 2018 оны 5 дугаар сард дуусгавар болж өөрсдөө урсгал засварыг байгууллагын төсвөөс гаргаж эхэлнэ. Урсгал засварт агаар, тосны шүүлтүүрүүд, цахилгаан хавхлагууд гэх мэт хугацаат сэлбэгийн 3 – 12 сарын хугацаанд солих шаардлагатай. Хэрвээ тус төв хүчилтөрөгч худалдах эрх зүйн бий болбол уг урсгал засваруудыг тогтмол хугацаанд тасралтгүй явуулж, бага хэрэглээтэй 2-3 эмнэлгийг тогтмол хүчилтөрөгчөөр хангах бүрэн боломжтой. Мөн баллон цэнэглэх насосны хүчин чадлыг нэмэгдүүлж, хоногт цэнэглэх баллоны тоог 2-3 дахин нэмэгдүүлэх боломжтой.

### 3.2.1 Баллонтой хүчилтөрөгч

Судалгаанд хамрагдсан эрүүл мэндийн байгууллагуудын 95% нь буюу баллонтой хүчилтөрөгч худалдан байдаг ба татан авах хугацааг дүрслэл.4-д харуулав.



*Дүрслэл 4. Эрүүл мэндийн байгууллагуудын баллонтой хүчилтөрөгч татан авах хугацаа*

Нэг баллон хүчилтөрөгчийн үнэ ханш газар байршлаас хамааран харилцан адилгүй байна. Жишээлбэл нийслэл хотод байршилтай эрүүл мэндийн байгууллага нэг баллон хүчилтөрөгчийг 7,440-өөс 12,000 төгрөгөөр, хөдөө орон

нутагт байршилтай эрүүл мэндийн байгууллага 11,000-аас 110,000 төгрөгөөр худалдан авч байна.

Улсын гуравдугаар төв эмнэлэг нь сар дунджаар 2000 гаран баллон хүчилтөрөгчийг нэг ширхгийг нь 8000 төгрөгөөр худалдан авдаг ба жилд ойролцоогоор 192,000,000 төгрөгийг хүчилтөрөгчийн худалдан авалтад зарцуулдаг.

Мөн Улаанбаатар хотоос хамгийн хол байрлах Баян-Өлгий аймгийн нэгдсэн эмнэлэг нь сард дунджаар 8-10 баллон хүчилтөрөгчийг нэг ширхгийг нь 110,000 төгрөгөөр худалдан авдаг ба жилд ойролцоогоор 13,200,000 төгрөгийг хүчилтөрөгчийн худалдан авалтад зарцуулж байна.

*Шигтгээ 3: Хөдөө орон нутгийн эмнэлэг хүнд өвчтөн байгаа үед хүчилтөрөгчийн нөөц дууссахад ойролцоох аймаг руу явж татан авах тохиолдол гардаг. Энэ нь баллонтой хүчилтөрөгчийг шаардлага хангаагүй тээврийн хэрэгслээр зөөвөрлөх мөн цаг алдвал өвчтөий амь насыг эрсдэлд үүсгэдэг.*

*Орон нутгийн төлөөлөл*

Баллонтой хүчилтөрөгчийн тээвэрлэлт болон буулгалтыг ханган нийлүүлэх байгууллага хариуцан ажилладаг 25, өөрсдөө хариуцан ажилладаг 17 эрүүл мэндийн байгууллага байна. Тээвэрлэлтийн үед дэр модтой 4, анхааруулах улаан тугтай 3, аюултай ачаа гэсэн тэмдэглэгээтэй 2, бүгд шаардлагыг хангасан 1, огт шаардлага хангаагүй 7 машинаар баллонтой хүчилтөрөгчийг зөөвөрлөдөг байна.

*Шигтгээ 4: Ханган нийлүүлэгч байгууллагаас авч байгаа хүчилтөрөгчийн баллоны зарим тохиолдолд эрүүл ахуйн шаардлага хангахгүй, өнгө үзэмж, дүүргэлт муутай ирдэг.*

*Эрүүл мэндийн байгууллагын төлөөлөл*

Баллонтой хүчилтөрөгч хадгалах байртай 37, хадгалах байргүй 7 эрүүл мэндийн байгууллага байна. Үүнээс нийт 26 эрүүл мэндийн байгууллагын хадгалах байр нь эмнэлгийн барилга дотор байрладаг. Баллонтой хүчилтөрөгч хадгалах байранд гадна хүн орохыг хориглосон тэмдэг, тэсэрч дэлбэрэх аюултай тэмдэг, баллоны бэхэлгээтэй байх гэсэн шаардлага тавигддаг боловч бүх шаардлагыг хангасан 16, нэгээс хоёр шаардлагыг хангасан 16, огт шаардлага хангаагүй 5 эрүүл мэндийн байгууллага байна.

**Баллонтой хүчилтөрөгч хадгалах байр****Хадгалах байрны байршил**

*Дүрслэл 5. Баллонтой хүчилтөрөгчийн хадгалах байр болон түүний байршил*

Баллонтой хүчилтөрөгч нь ойролцоогоор 90 кг жинтэй байдаг бөгөөд эмнэлэг дотор баллонтой хүчилтөрөгчийг зориулалтын тэргэнцрээр 26, зориулалтын бусаар 18 эрүүл мэндийн байгууллага зөөвөрлөдөг. Мөн давхар хооронд цахилгаан шатаар зөөвөрлөдөг 12 байгууллага байна.

*Шигтгээ 5: Эмнэлэг дотор давхар хооронд 2 хүн баллонтой хүчилтөрөгчийг дамжлан зөөвөрлөж байх үедээ нэгэн гар алдаж унагасан тохиолдол гарсан. Тухайн үед нэг ажилтан сэргэлэн самбаатай, чадалтай хүн байсан тул хүчилтөрөгчийн баллоны хөдөлгөөнийг хязгаарлаж чадсан. Хэрэв тухайн үед шатны тавиурд баллоны толгой цохигдон оч үсэрсэн бол ямар эрсдэл гарахийг тааварлашгүй.*

*Эрүүл мэндийн байгууллыгнын төлөөлөл*


Хэсэгчилсэн хүчилтөрөгчийн системтэй 21 эрүүл мэндийн байгууллага байдаг ба нэг удаад 1-5 ширхэг баллон зэрэг залгадаг 11, 6-10 ширхэг баллон 10 эрүүл мэндийн байгууллага байна.

Хэсэгчилсэн хүчилтөрөгчийн системийг 100% гар аргаар сэлгэн залгалт хийдэг. Мөн хэрэглэгчээс хамаарч дахин залгах хугацаа харилцан адилгүй байдаг. Дунджаар 2-10 цагийн хугацаанд сэлгэн залгалт хийдэг байна.



2017 оны 8 сарын байдлаар 44 эрүүл мэндийн байгууллагуудын 217 тасаг нэгжид эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хүчилтөрөгч, нүүрстөрөгчийн хийг ашиглаж байна. Нарийвчласан харьцуулалтыг дүрслэл.6-д харуулав. Орон нутгийн 21 эрүүл мэндийн байгууллагаас 17 нь зөөврийн хүчилтөрөгч ашиглаж байна.

### Эмнэлгийн хийн хангамжийн ашиглалт



#### Дүрслэл 6. Эмнэлгийн хийн хангамжийн ашиглалт

Тасаг нэгжүүдэд байгаа хийн хангамжийн нэгдсэн систем, хэсэгчилсэн хүчилтөрөгчийн системийн бүдүүвч зургийг судалгаанд хавсаргах ёстой байсан ч эрүүл мэндийн байгууллагуудын ирүүлсэн бүдүүвч зураг ойлгомжгүй, өөр өөр байгаа тул баримтлуулах хадгалах боломжгүй байна.

**БҮЛГИЙН ДҮГНЭЛТ:** Монгол улсын эрүүл мэндийн салбарын хэмжээнд 2 эрүүл хүчилтөрөгчийн үйлдвэр хангалтгүй байна. Хөдөө орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудыг бүсчилсэн хүчилтөрөгчийн үйлдвэр байгуулах хэрэгцээ шаардлага тулгарч байна.


Мөн хүчилтөрөгчийн үйлдвэрүүдийг бүрэн чадлаар нь ашиглаж, нөөц баллонтой хүчилтөрөгчийг худалдах эрх зүйн орчинг бүрдүүлснээр чанартай бага үнэтэй хүчилтөрөгчөөр эрүүл мэндийн байгууллагыг хангаж, тус үйлдвэр тасралтгүй ажиллах боломжийг өөрийн орлогоос бүрдүүлэх боломж бүрдэх юм.

Хүчилтөрөгч ханган нийлүүлэгч байгууллагад тавигдах шаардлага, болон эмнэлгийн хийн хангамжийн систем, хүчилтөрөгчийн хэсэгчилсэн систем, баллонтой хүчилтөрөгчийн тээвэрлэлт, буулгалт, зөөвөрлөлт, ашиглалт,

хүчилтөрөгчийн шугам хоолойн бүдүүвч зурагт тавигдах ерөнхий шаардлага, нэгдсэн дүрэм, журам, стандартыг бий болгох зайлшгүй шаардлага тулгарч байна.

### 3.3 ХИЙН ХАНГАМЖИЙН СИСТЕМИЙН ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

Эмнэлгийн хийн хангамжийн нэгдсэн систем болон хэсэгчилсэн хүчилтөрөгчийн системтэй болох шаардлагатай 35 эрүүл мэндийн байгууллагын нийт 199 тасаг нэгж байна. Тус эрүүл мэндийн байгууллагуудад нийт 978 ширхэг хүчилтөрөгч болон нүүрстөрөгчийн баллон шаардлагатай бөгөөд дүрслэл.7-д хэрэгцээ шаардлагыг нэгтгэн харуулав.



Дүрслэл 7. Эмнэлгийн хийн хангамжийн хэрэгцээ шаардлага  
/тоо ширхгээр/

Мөн эрүүл мэндийн байгууллага тус бүрээр гарсан хэрэгцээ, шаардлагыг хавсралт.1-д харна уу.

Судалгаа ирүүлсэн 9 эрүүл мэндийн байгууллага эмнэлгийн хийн хангамжийн нэгдсэн систем болон хэсэгчилсэн хүчилтөрөгчийн системтэй болоход шаардлагатай төсвийг боловсруулан нийт 826 сая төгрөгийн төсөв шаардлагатай гэж үзсэн байна. Харин үлдсэн 35 эрүүл мэндийн байгууллага шаардлагатай төсвийг ирүүлээгүй гэвч дээрх тооцоолол зөв, ямар төлөвлөлтөөр хийн нь тодорхойгүй тул нийт шаардлагатай нийт төсвийг гаргахад хүндрэлтэй байна.

**Бүлгийн дүгнэлт:** Судалгаанд хамрагдсан эрүүл мэндийн байгууллагын 79,5% нь эмнэлгийн хийн хангамжийн нэгдсэн систем болон хэсэгчилсэн хүчилтөрөгчийн системтэй болох гэсэн саналтай байгаа нь өнөөдөр эрүүл мэндийн тусламж үзүүлэхэд эмнэлгийн хийн хангамжийн нэгдсэн систем хангалтгүй байгаа нь харагдаж байна.

### 3.4 ХИЙН ХАНГАМЖИЙН СИСТЕМИЙН СУРГАЛТ, АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА


Хүчилтөрөгч нь маш шатамхай, тэсэрч дэлбэрэх аюултай хий юм. Нэг баллонтой хүчилтөрөгчийн дэлбэрч тухайн эмнэлгийн бүхэлд аюул учруулах боломжтой.

Мөн Монгол Улсын Хөдөлмөрийн аюулгүй байдал, Эрүүл ахуйн хуулийн 18.1.3 дугаар зүйлд “Ажлын байрны нөхцөл, эрүүл мэндэд учирч болох эрсдэл, түүнчлэн үйлдвэрлэлийн аюултай, хортой хүчин зүйлийн талаар бодит мэдээлэл авах” гэж заасан байдаг тул эрүүл мэндийн байгууллагын хийн хангамжийн системтэй харьцан ажилладаг эмч, сувилагч, мэргэжилтэн нарыг аюулгүй ажиллагааны сургалтад хамруулах, шинэ ажилтан зааварчилгаа өгөх нь зайлшгүй шаардлагатай асуудал юм.

#### 3.4.1 Аюулгүй ажиллагааны сургалт болон давтамж

Судалгаанд хамрагдсан эрүүл мэндийн байгууллагуудаас нийт 26 байгууллагын холбогдох ажилтнууд хийн хангамжийн системтэй харьцан ажилладаг эмч, сувилагч, мэргэжилтэн нарт аюулгүй ажиллагааны сургалтад явуулдаг байна. Үүнээс жил нэг удаа 13, жил хоёр удаа 13 эрүүл мэндийн байгууллага сургалт зохион байгуулдаг. Хамгийн сүүлд аюулгүй ажиллагааны сургалтыг 2016 оноос 2017 оны 7 сарын 26-ны өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулсан бөгөөд нийт 1228 эмч, сувилагч, мэргэжилтэн нар сургалтад хамрагдсан байна.

#### Аюулгүй ажиллагааны сургалт



#### Сургалтын давтамж



Дүрслэл 8. Эмч, сувилагч, мэргэжилтэн нар зориулсан хийн хангамжийн системийн аюулгүй ажиллагааны сургалт явуулдаг байгууллага болон сургалтын давтамж

Мөн шинээр ажилд орж буй эмч, сувилагч, мэргэжилтэн нарт эмнэлгийн хийн хангамжийн систем болон хүчилтөрөгчтэй ажиллах аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгдөг нийт 31 эрүүл мэндийн байгууллага байна.

### **3.4.2 Хийн хангамжийн систем болон хүчилтөрөгчтэй ажиллах аюулгүй ажиллагаа зааварчилгаа**

Эмнэлгийн хийн хангамжийн систем болон хүчилтөрөгчтэй ажиллах аюулгүй ажиллагааны зааварчилгаа нь ажилтныг уншихад ойлгомжтой, аюулгүй ажиллагааны бүхий л заалтуудыг тусгасан, хэрэглэхэд ойр байх нь нэн чухал юм.

Судалгаанд хамрагдсан нийт 38 эрүүл мэндийн байгууллагад аюулгүй ажиллагааны зааварчилгаатай бөгөөд үүнээс 37 нь харьцан ажилладаг ажилтан аюулгүй ажиллагааны зааварчилгааг ойр байршуулдаг байна. Мөн эмнэлгийн хийн нэгдсэн систем, хүчилтөрөгчийн баллоны хажууд аюулгүйн тэмдэг тэмдэглэгээ байршуулж хэвшсэн 33 эрүүл мэндийн байгууллага байна.

**БҮЛГИЙН ДҮГНЭЛТ:** Эмч, сувилагч нарт зориулсан аюулгүйн ажиллагааны сургалтыг хангалттай явуулахгүй байна. Эмнэлгийн хийн хангамжийн систем харьцан ажилладаг болон шинэ аюулгүй ажиллагааны сургалт тогтмол явуулах шаардлага байна.

Мөн аюулгүй зааварчилгаа болон аюулгүй тэмдэгтийн ажилтанд хамгийн ойр байхаар байрлуулж, уг зааварчилгааг мөрдөн ажиллахыг хэвшил болгон ажиллах шаардлагатай байна.

## **3.5 ХИЙН ХАНГАМЖТАЙ ХОЛБООТОЙ ГАРСАН ОСОЛ ГЭМТЭЛ**

Өмнө нь хүчилтөрөгчийн аюулыг тухай дурдсан тул эмнэлгийн хийн хангамжтай холбоотой гарсан осол гэмтлийн мэдээллийг нэгтгэн цаашид анхаарал хандуулах нь чухал асуудал юм.

Судалгаанд хамрагдсан 44 эрүүл мэндийн байгууллагаас эмнэлгийн хийн системтэй холбоотой 4 осол гарч байсан бөгөөд хүчилтөрөгчийн шугам битүүлж алдагдсан 3, ажилтан гэмтсэн 1 тохиолдол гарсан байсан.

Хүчилтөрөгчийн шугамын бүтээмж алдагдсанаас Дархан-Уул аймгийн нэгдсэн эмнэлэгт 2016 оны 6 дугаар сарын 20-ны өдөр хүүхдийн тасгийн хүчилтөрөгчийн редукторт гэмтэл гарч хүчилтөрөгчийн шугам руу угарын хий орсон гэмтэл гарч байсан.

Мөн 2016 онд Сүхбаатар аймгийн нэгдсэн эмнэлгийн хийн хангамж хариуцсан ажилтан хүчилтөрөгчийн баллон зөөвөрлөж байх үедээ зориулалтын тэргэнцэр байхгүйгээс унагаж гараа гэмтээсэн боловч, хөндлөнгийн гэрч байгаагүй учир эмнэлгийн удирдлагаас ямар нэгэн арга хэмжээ аваагүй байна.

**БҮЛГИЙН ДҮГНЭЛТ:** Цаашид гарч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж, аюулгүй ажиллагааны дүрмийг чандлан сахиж, байгууллагын удирдлагын зүгээс хариуцан ажилладаг ажилтанг сургах, аюулгүй ажиллагааны хувцас хэрэгслээр тогтмол ханган ажиллах, хийн хангамжийн системтэй ажилладаг эмч, сувилагч нарыг шинээр ажилд орох, мөн тогтмол эмнэлгийн хийн хангамжийн системийн аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулах зэрэг ажлуудыг хийх шаардлагатай байна.

## ДҮГНЭЛТ

Судалгаанд төрийн өмчийн хоёр, гурав дахь шатлалын нийт 44 эрүүл мэндийн байгууллагад буюу Эрүүл мэндийн яамны харьяа 3 төв эмнэлэг, 8 тусгай мэргэжлийн төв, Нийслэлийн эрүүл мэндийн газрын харьяа дүүргийн 9 эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлэг, 3 амаржих газар, 4 бүсийн оношилгоо, эмчилгээ төв, 16 аймгийн нэгдсэн эмнэлэг тус тус хамрагдсан.

Судалгааны үр дүнг харахад эмнэлгийн хийн хангамжийн системийн хариуцан ажилладаг тоо хангалтгүй ба ажил үүргийн хуваарь ижил боловч албан тушаалын нэршил өөр өөр байна. Хөдөө орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудад ихэвчлэн ачаалалтай ажилладаг эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженерүүд хүчилтөрөгчийг хариуцан ажилладаг бөгөөд мэргэшүүлэх сургалтад огт хамрагдаж байгаагүй, мөн хавсран гүйцэтгэсний нэмэгдэл цалин огт авдаггүй байна. Иймд цаашид хүний нөөцийг нэмэгдүүлж, хавсран гүйцэтгэсний цалинг олгож байх шаардлагатай байна.

Монгол улсын хэмжээнд УНТЭ, ГССҮТ нь өөрийн хүчилтөрөгчийн систем боловч тус үйлдвэрийн хүчин чадлыг бүрэн ашиглахгүй байгаа тул цаашид эмнэлэг нөөц хүчилтөрөгчийг худалдан авах боломжийг бүрдүүлэн урсгал засварыг өөрийн орлогоос төвлөрүүлэн тасралтгүй, хэвийн үйл ажиллагааг хангах боломж нөхцөлийг бүрдэх шаардлагатай.

Эрүүл мэндийн байгууллага тус бүрээр эмнэлгийн хийн хангамжийн системийн ашиглалт, түүнтэй холбоотой дагалдах үйл ажиллагаа өөр өөр түвшин байна. Иймд цаашид хүчилтөрөгч ханган нийлүүлэгч байгууллагад тавигдах шаардлага, болон эмнэлгийн хийн хангамжийн систем, хүчилтөрөгчийн хэсэгчилсэн систем, баллонтой хүчилтөрөгчийн тээвэрлэлт, буулгалт, зөөвөрлөлт, ашиглалт, хүчилтөрөгчийн шугам хоолойн бүдүүвч зурагт тавигдах ерөнхий шаардлага, нэгдсэн дүрэм, журам, стандартыг бий болгох зайлшгүй шаардлага тулгарч байна.

Өнөөдөр олон улсад эмнэлгийн хийн хангамжийн систем гэсэн өргөн ойлголтоор эрүүл мэндийн тусламж үйлчилгээг ашиглагдаж байгаа бол манай төрийн өмчийн хоёр, гурав дахь шатлалын эрүүл мэндийн байгууллагад ашиглагдаж байгаа тус үйл ажиллагаа хангалтгүй, одоог хүртэл баллонтой хүчилтөрөгчийн зөөвөрлөсөөр байгааг шинэчлэл хийгдэх болсныг харуулж байна.

Хүчилтөрөгч нь маш шатамхай, тэсэрч дэлбэрэх аюултай хий юм. Нэг баллонтой хүчилтөрөгчийн дэлбэрч тухайн эмнэлгийн бүхэлд аюул учруулах боломжтой тул хүчилтөрөгчтэй харьцан ажилладаг болон шинээр ажилд орж буй эмч, сувилагч нарт зориулсан аюулгүйн ажиллагааны сургалтыг хангалттай явуулахгүй байна. Иймд аюулгүй ажиллагааны сургалт тогтмол явуулж, аюулгүй зааварчилгаа болон аюулгүй тэмдэгтийн ажилтанд хамгийн ойр байхаар байрлуулж, уг зааварчилгааг мөрдөн ажиллахыг хэвшил болгон ажиллах шаардлагатай байна.

Тулгарч буй асуудлыг шийдвэрлэхийн тулд дараах арга хэмжээнүүдийг авах хэрэгтэй байна. Үүнд:

#### **Эрүүл мэндийн яам**

1. Эмнэлгийн хийн хангамжийн системд тавигдах шаардлага, холбогдох дүрэм журам стандартыг боловсруулах ажлын хэсэг томилон ажиллуулах.
2. Эрүүл мэндийн байгууллагуудын эмнэлгийн хийн хангамжийн системийг хариуцан ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг судалж, албан тушаалын нэршлийг ижил болох, цаашид орон тооны ажилтанг ажиллуулах болон хавсран гүйцэтгэсэн цалин олгох анхаарал хандуулах.
3. Хүчилтөрөгчийн үйлдвэрийн нөөц хүчилтөрөгчөө худалдах, олгосон орлого захиран зарцуулах эрх орчинг бий болгож хүчин чадлыг бүрэн ашиглах.
4. Хөдөө орон нутгийн эрүүл мэндийн байгууллагууд хүчилтөрөгч хариуцсан ажилтан нарт зориулсан аюулгүй ажиллагааны сургалтыг зохион байгуулах санхүүжилтийг гаргах.

#### **Эрүүл мэндийн хөгжлийн төв**

1. Эмнэлгийн хийн хангамжийн системд тавигдах шаардлага, холбогдох дүрэм журам стандартыг боловсруулах ажлын хэсгийг мэдээллээр хангах.
2. Хөдөө орон нутгийн эрүүл мэндийн байгууллагууд хүчилтөрөгч хариуцсан ажилтан зориулсан аюулгүй ажиллагааны сургалтыг зохион байгуулах.

#### **Эрүүл мэндийн байгууллага**

1. Монгол Улсын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хуулийн 18.1.1, 18.1.3, 18.2.5 болон Хөдөлмөрийн тухай хуулийн 50.2, 50.3 дугаар заалтуудыг мөрдөн ажиллах.
2. Хүчилтөрөгчийн хариуцан орон тооны ажилтантай болох, тэднийг мэргэшүүлэх сургалтад заавал хамруулах.

3. Хавсран хүчилтөрөгчийг хариуцан ажилладаг ажилтанд нэмэгдэл цалинг олгож, ажилтныг үүрэгжүүлэх.
4. Хүчилтөрөгч хадгалах байр, баллонтой хүчилтөрөгчийг ашиглахад болон тээвэрлэж буй машинд тавигдах аюулгүй ажиллагааны шаардлагуудыг биелүүлэх.
5. Ажиллаж буй болон шинэ ажилд орж байгаа хүчилтөрөгч хариуцсан ажилтан, хүчилтөрөгчтэй харьцан ажиллах эмч, сувилагч, мэргэжилтэн тогтмол аюулгүй ажиллагааны сургалт, зааварчилгааг тогтмол өгөх байх ажлыг зохион байгуулах.
6. Эмнэлэг дотор хүчилтөрөгч зөөвөрлөх тэргэнцэртэй заавал болох.
7. Хүчилтөрөгчийн хариуцан ажилтанг хамгаалалтын хувцас хэрэглэлээр хангах.



Хавсралт.1

**ХОЁР БОЛОН ГУРАВДУГААР ШАТЛАЛЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН  
БАЙГУУЛЛАГУУДЫН ЭМНЭЛГИЙН ХИЙН ХАНГАМЖИЙН СИСТЕМИЙН  
ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА**

№	Тасаг нэгжийн нэр	Холболт хийх шаардлагатай орны тоо	Шаардлагатай			Шаардлагатай төсөв
			Хийн нэгдсэн систем	Хэсэгчилсэн хүчилтөрөгчийн систем	Баллоны тоо	
<b>1. Улсын Нэгдүгээр Төв Эмнэлэг</b>						
1	Гастро-энтерологийн төв	4	1			
2	Бүдүүн шулуун гэдэсний мэс заслын тасаг	2	1			
3	Эрүү нүүрний мэс заслын тасаг	2	1			
4	Чих хамар хоолой судлалын тасаг	2	1			
5	Ерөнхий мэс заслын тасаг - 1	4	1			
6	Ерөнхий мэс заслын тасаг - 2	4	1			
7	Урилоги, андрологийн төв	4	1			
8	Зүрх судасны эмгэг судлалын тасаг	4	1			
9	Цусны эмгэг судлал, чөмөг шилжүүлэн суулгах төв	4	1			
10	Дотоод шүүрэл судлал, диабетийн төв	4	1			
<b>2. Улсын Хоёрдугаар Төв Эмнэлэг</b>						
		0	0	0	0	-
<b>3. Улсын Гуравдугаар Төв Эмнэлэг</b>						
11	Бөөр дотоод шүүрлийн эмгэг судлалын тасаг	10	1			7,250,000
12	Уушиг судлалын тасаг	15	1			6,256,000
13	Хоол боловсруулах эрхтэн тогтолцооны эмгэг судлалын тасаг	6	1			5,826,000

14	Мэдрэлийн мэс заслын тасаг	7	1			6,362,000
15	Мэдрэлийн эмгэг судлалын тасаг	4	1			4,625,000
16	Зүрхний эмгэг судлалын тасаг	10	1			4,050,000
17	Ерөнхий мэс заслын тасаг	6	1			1,250,000
18	Чих хамар хоолойн мэс заслын тасаг	одоогоор байхгүй		1		2,150,000
					33	16,500,000
<b>4. Гэмтэл согог судлалын үндэсний төв</b>						
19	Төлөвлөгөөт хагалгаа	3	1		3	
20	Түлэнхий хагалгаа	2	1		2	
<b>5. Хавдар судлалын үндэсний төв</b>						
21	Туяа тасаг	8		1	3	900,000
22	Хүлээн авах	1		1	1	300,000
23	Ангиограф	4		1	2	600,000
24	Элэг цөсний мэс засал	24	1			
<b>6. Халдварт өвчин судлалын үндэсний төв</b>						
25	Халдвартын 1-р тасаг /Агаар дуслын/		1			40,000,000
26	Халдвартын 2-р тасаг /Зоонозын/			1		120,000,000
27	Халдвартын 3-р тасаг			1		
28	Халдвартын 4-р тасаг /Гэдэсний халдварын тасаг			1		
29	Халдвартын 5-р тасаг /Насан хүрэгчдийн /эр/ цочмог гипатитын тасаг/			1	10	
30	Халдвартын 6-р тасаг /Насан хүрэгчдийн /эм/ цочмог гипатитын тасаг/			1		
31	Халдвартын 7-р тасаг /шинэ болон дахин сэргэж буй халдварын тасаг			1		
32	Халдвартын 8-р тасаг/ Элэгний клиник/			1		

33	Яаралтай тусламж, хүлээн авах тасаг			1	5	10,000,000
34	Сүрьеэгийн клиникийн хүлээн авах		1			5,000,000
<b>7. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв</b>						
<b>8. Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв</b>						
<b>8.1 Эх барих эмэгтэйчүүдийн эмнэлэг</b>						
35	Төрөх тасаг	3		1	0	2,757,000
36	Эх барих эмэгтэйчүүдийн эмнэлэг-Төрсний дараах тасаг	8		1	4	6,672,000
<b>8.2 Хүүхдийн эмнэлэг</b>						
37	Бөөрний мэс заслын тасаг	4		1	2	3,656,000
38	Нүдний мэс заслын тасаг	2		1	1	1,985,000
39	Эрүү нүүрний мэс заслын тасаг	4		1	1	3,587,000
40	Чих хамар хоолойн мэс заслын тасаг	8		1	2	5,672,000
41	Нярай судлалын тасаг	15 /Агаарын компрессор шаардлагатай/	1			45,000,000
42	Хүүхдийн эрчимт эмчилгээ	18 /Агаарын компрессор шаардлагатай/	1			52,000,000
43	Мэс заслын эрчимт эмчилгээ	6 /Агаарын компрессор шаардлагатай/	1			30,000,000
<b>9. Арьсны өвчин судлалын үндэсний төв</b>						
<b>10. Зоонокийн өвчин судлалын үндэсний төв</b>						
<b>11. Хүүхдийн төв судилал</b>						
<b>12. Өргөө амаржих газар</b>						
44	Хүлээн авах яаралтай тусламжийн хэсэг		1		2	
45	Төрөх хэсэг		1		5	
46	Дутуу тээлтийн ажилбарын хэсэг		1		2	
47	Жирэмсний эмгэгийг эмчлэх хэсэг		1		1	
48	Төрсний дараах хэсэг		1		1	
49	Мэс заслын дараах хэсэг		1		1	

50	Гүйцэд нярайн хэсэг		1		2	
51	Сэхээн амьдруулах яаралтай тусламжийн хэсэг		1		2	
<b>13. Хүрээ Амаржих газар</b>						
52	Мэс засал мэдээгүйжүүлэг эрчимт эмчилгээний тасаг	13	1			300,000,000
53	Яаралтай тусламж хүлээн авах тасаг		1			
54	Нярайн тасаг	29	1			
55	Төрөх тасаг	10	1			
56	Төрсний дараах тасаг	45	1			
57	Жирэмсний эмгэг эмчлэх тасаг	39	1			
<b>14. Амгалан амаржих газар</b>						
<b>15. Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төв</b>						
58	Хэвтэн эмчлүүлэх	90	1			
59	Гемодиализ	3	1			
60	Хүлээн авах	2	1			
61	Эрчимт эмчилгээ	2	1			
<b>16. Баянгол дүүргийн Эрүүл мэндийн төв</b>						
62	Мэс засал	4	1			
63	Гемодиализ	2	1			
64	Эрчимт эмчилгээ	3	1			
65	Яаралтай тусламж	3	1			
<b>17. Багануур дүүргийн Эрүүл мэндийн төв</b>						
66	Мэс заслын тасаг	21		1		
67	Төрөх тасаг	29		1		
68	Хүүхэд тасаг	38		1		
69	Дотор тасаг	58		1		
70	Мэдрэл тасаг	13		1		
71	Эрчимт эмчилгээ	4		1		
72	Халдварт	23		1		
<b>17. Багануур дүүргийн Эрүүл мэндийн төв</b>						
<b>18. Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төв</b>						
73	Мэс заслын тасаг	4		1		
74	Төрөх тасаг	5		1		
75	Хүүхэд тасаг	5		1		
76	Дотор тасаг	5		1		
77	Мэдрэл тасаг	5		1		

78	Эрчимт эмчилгээ	4	1			
79	Халдварт	5		1		
<b>19. Налайх дүүргийн Эрүүл мэндийн төв</b>						
80	Сэхээний тасаг	4	1		2	
81	Төрөх эмэгтэйчүүдийн тасаг	2	1		1	
82	Хагалгаа	2	1		1	
<b>20. Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн төв</b>						
<b>21. "Баянзүрх Эмнэлэг" ХХК</b>						
<b>22. Хан-Уул Нэгдсэн эмнэлэг</b>						
83	Насанд хүрэгчдийн тасгийн эрчимт эмчилгээ	4	1		3	
<b>23. Сонгинохайрхан дүүргийн Нэгдсэн эмнэлэг</b>						
84	Эрчимт эмчилгээний тасаг	5		1		1,000,000
85	Хүүхдийн тасгийн эрчимт эмчилгээ	4	1		3	
<b>24. Баян-Өлгий АНЭ</b>						
86	Мэс засал болон хагалгаанд	6	1			
87	Лор болон хагалгаанд	4	1			
88	Сэхээний тасаг	8	1			
89	Мэдрэлийн тасаг	4	1			
90	Хүүхдийн тасаг	6	1			
91	Төрөх болон хагалгаанд	6	1			
92	Нярайн хэсэгт	4	1			
93	Доторийн тасаг	4	1			
94	Сүрьеэгийн тасаг	4	1			
95	Халдвартийн тасаг	4	1			
<b>25. Булган АНЭ</b>						
96	Төрөх эмэгтэйчүүдийн эмнэлгийн төрөх болон хагалгааны блокууд	50		1	3	
97	Нэгдсэн эмнэлгийн Сэхээн амьдруулах тасаг	20		1	3	
98	Нэгдсэн эмнэлгийн Мэс заслын тасгийн хагалгааны блок	2		1	3	

26. Дархан-Уул АНЭ						
99	Төрөх тасаг	50	1		10	
100	Халдварт	20		1	2	
101	Гэмтэл	34		1	2	
102	Мэс засал	28		1	2	
103	Дотор	70		1	2	
104	Мэдрэл	30	1		3	
105	Яаралтай тусламж		1		4	
27. Говьсүмбэр АНЭ						
106	Мэс заслын тасаг			1		
107	Эрчимт эмчилгээний тасаг			1		
108	Төрөх тасаг			1		
109	Яаралтай тусламжийн тасаг			1		
28. Хөвсгөл АНЭ						
110	Мэдээгүйжүүлэг эрчимт эмчилгээний тасаг	4	1		6	
111	Хүүдийн тасаг	4	1		6	
29. Хэнтий АНЭ						
30. Сүхбаатар АНЭ						
112	Мэс засал	2	1			
113	Дотор	2	1			
114	Мэдрэл	2	1			
115	Хүүхэд	4	1			
116	Төрөх	6	1			
117	ХАЯТТ, сэхээн	4	1			
118	Халдварт	2	1			
31. Увс АНЭ						
119	Мэс засал		1		50	40,000,000
120	Эрчимт эмчилгээ мэдээгүйжүүлэг		1			
121	Төрөх			1		
122	Хүүхэд		1			
123	Дотор		1			
32. Завхан АНЭ						
124	Төрөх эмэгтэйчүүдийн эмнэлгийн төрөх болон хагалгааны блокууд	50		1	3	
125	Нэгдсэн эмнэлгийн Сэхээн амьдруулах тасаг	20		1	3	

126	Нэгдсэн эмнэлгийн Мэс заслын тасгийн хагалгааны блок	2		1	3	
<b>33. Архангай АНЭ</b>						
127	Мэс заслын тасаг-хагалгааны хэсэг	3 ор	1			
128	Дотрын тасаг	4 ор	1			
129	Мэдрэлийн тасаг	2 ор	1			
130	САЭЭ-ий тасаг	4 ор	1			
131	НҮЭМК	8 ор		1		
132	хүүхэд	8 ор		1		
133	халдварт сүрьеэ	2 ор		1		
<b>34. Төв АНЭ</b>						
134	СЭЭЯТ	8	1			
135	Сүрье	4	1			
136	Халдварт	4	1			
137	Хүүхэд	4	1			
138	Төрөх	4	1			
139	Мэдрэл	3	1			
140	Мэс засал	5	1			
141	дотор	4	1			
142	Уламжлалт	2	1			
<b>35. Сэлэнгэ АНЭ</b>						
143	Нэгдсэн хагалгаа	4	1			
144	Нэгдсэн сэхээ	5	1			
145	Хүүхдийн сэхээ	7	1			
146	Төрөх нярай	7	1			
147	Яаралтай тусламж	3	1			
148	Диалез	3	1			
<b>36. Баянхонгор АНЭ</b>						
149	Эрчимт эмчилгээ, мэдээгүйжүүлэг, гемодиализын тасагт	5	1		5	1425000
150	Дотрын тасагт	45	1		2	570000
151	Төрөх эмэгтэйчүүдийн тасаг	75	1		3	855000
<b>37. Өвөрхангай АБОЭТ</b>						
152	Эрчимт эмчилгээ	4		1		
153	Хагалгааны нэгдсэн тасаг	4		1		
154	Хүүхэд	3		1		
155	Төрөх хагалгаа	1		1		
156	Нярай	3		1		
<b>38. Дорнод АБОЭТ</b>						
157	Төрөх /нярай/		1			

158	Төрөх /хагалгаа/		1			
159	Мэс 1		1			
160	Мэс 2		1			
161	Хүүхэд		1			
162	Сэхээн амьдруулах тасаг		1			
163	Хүлээн авах		1			
164	Халдварт		1			
165	Сүрьеэ		1			
<b>39. Ховд АБОЭТ</b>						
166	Сэхээн		1	4		10000000
167	Мэс засал		1	2		10000000
168	Гэмтэл		1	2		10000000
169	Төрөх		1	4		10000000
170	Эмэгтэйчүүд		1	2		10000000
171	103 хүлээн авах		1	2		10000000
172	Хүүхэд		1	2		10000000
173	Дотор		1	2		10000000
174	Мэдрэл		1	2		10000000
175	Халдварт		1	2		10000000
<b>40. Өмнөговь АБОЭТ</b>						
176	сэхээн	4	1		18	
177	төрөх нярайд	5	1			
178	Мэс засал	2	1			
179	Яаралтай тусламжийн тасаг	3	1			
<b>41. Дундговь АНЭ</b>						
180	Төрөх	20	1		2	
181	Яаралтай тусламж мэдээгүйжүүлэг эрчимт эмчилгээ	5	1		2	
182	Халдварт	11	1		1	
183	Мэс засал	15	1		3	
<b>42. Дорноговь АНЭ</b>						
184	Мэс засал			1	48	
185	Дотор			1		
186	ЯТМЭЭ тасаг			1		
187	Төрөх			1		
188	Хүүхэд			1		
<b>43. Алтай АНЭ</b>						
189	Мэс заслын тасаг		1			
190	Мэдээгүйжүүлэг, эрчимт эмчилгээний тасаг		1			
191	Яаралтай тусламжийн тасаг		1			



192	Төрөх эмэгтэйчүүдийн тасаг		1			
193	Хүүхдийн тасаг		1			
194	Дотрын тасаг		1			
195	Мэдрэлийн тасаг		1			
<b>44. Орхон АБОЭТ</b>						
196	Төрөх	8		1		
197	Хүүхэд	8		1		
198	Гэмтэл	4		1		
199	Мэс	4		1		
	<b>Нийт</b>		<b>124</b>	<b>74</b>	<b>308</b>	<b>826,248,000</b>

Хавсралт.2

**ХОЁР БОЛОН ГУРАВДУГААР ШАТЛАЛЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН  
БАЙГУУЛЛАГУУДАД ШААРДЛАГАТАЙ ХҮЧИЛТӨРӨГЧ  
БОЛОН НҮҮРСТӨРӨГЧИЙН БҮРТГЭЛ БОЛОН  
ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА**

№	Эрүүл мэндийн байгууллагын нэр	Байгууллагын үндсэн хөрөнгийн бүртгэлтэй хүчилтөрөгчийн баллоны тоо	Шаардлагатай хүчилтөрөгчийн баллоны тоо	Байгууллагын үндсэн хөрөнгийн бүртгэлтэй нүүрстөрөгчийн баллоны тоо	Шаардлагатай нүүрстөрөгчийн баллоны тоо
1	УНТЭ	64	10	1	2
2	УХТЭ	6	20	6	2
3	УГТЭ	67	100		4
4	ГССҮТ	50-38, 15-10, 5-25			
5	ХСҮТ	40	120	3	10
6	ХӨСҮТ	23	50		10
7	СЭМҮТ	6	-	-	-
8	ЭХЭМҮТ	112	20	11	5
9	АӨСҮТ	5	5	5	5
10	ЗӨСҮТ	-	-	2	3
11	ХТС	0	0	0	0
12	Өргөө АГ	43	37		2
13	Хүрээ АГ	10	5		
14	Амгалан АГ	15	15		
15	Хан-Уул ЭМТ	2	5		
16	Баянгол ДЭМТ	8	0	0	0
17	Багануур ЭМТ	14	10	1	1
18	Чингэлтэй ЭМТ	9	1	0	0
19	Налайх ЭМТ	4	4	0	6
20	Сонгинохайрхан ЭМТ	5	5	0	0
21	Баянзүрх эмнэлэг ХХК	14	0	0	0
22	Сонгинохайрхан НЭ	5	5	0	0
23	Хан-Уул НЭ	6	12	0	0
24	Баян-Өлгий АНЭ	10	120	5	10
25	Булган АНЭ	5	10	0	0
26	Дархан-Уул	24	70		2
27	Говьсүмбэр АНЭ	12	0	0	0
28	Хөвсгөл АНЭ	0	25	0	2
29	Хэнтий АНЭ	24	0	3	0
30	Сүхбаатар АНЭ	4	16	0	4
31	Увс АНЭ	31	19	1	4

32	Завхан АНЭ	5	10	0	0
33	Архангай	12	0	0	0
34	Төв АНЭ	0	40	0	4
35	Сэлэнгэ АНЭ	12	20	2	4
36	Баянхонгор АНЭ	15	10	0	0
37	Өвөрхангай АБОЭТ	5	25	0	2
38	Дорнод АБОЭТ	10	5	2	2
39	Ховд АБОЭТ	10	20	2	1
40	Өмнөговь АБОЭТ	18	0	2	0
41	Дундговь АНЭ	15	10	1	2
42	Дорноговь АНЭ	48	0	2	0
43	Говь-Алтай АНЭ	5	10	0	0
44	Орхон АБОЭТ	15	50	11	11
	<b>Нийт</b>	<b>738</b>	<b>884</b>	<b>60</b>	<b>98</b>